



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/21/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2021 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn Аудитор: Ж.Баяртуул Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
Аудитын зөвлөмж.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Менежментийн захидал	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 121
танай _____-ны № _____-т

Г УРВАНЗАГАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ О.БОДЬЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг цар тахлын хорио цээрийн нөхцөл байдлаас шалтгаалан дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021225

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,805,905.55	51,706,763.54
33	АВЛАГА	250,000.00	1,584,887.42
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,334,887.42
335	Бусад авлага	250,000.00	250,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	250,000.00	250,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	33,555,905.55	50,121,876.12
354	Хангамжийн материал	33,555,905.55	50,121,876.12
35410	Бичиг хэргийн материал	3,982,661.55	6,870,426.12
35420	Аж ахуйн материал	24,357,856.00	30,597,753.00
35450	Барилгын засварын материал	-	8,267,518.00
35460	Хүнсний материал	5,215,388.00	4,386,179.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,078,641,335.30	1,205,919,378.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,078,641,335.30	1,205,919,378.69
392	Биет хөрөнгө	1,034,878,935.30	1,162,156,978.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	926,899,613.66	1,088,279,539.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,584,425.57)	(42,926,583.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,514,702.40	88,273,979.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,709,674.73)	(51,973,269.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,641,124.00	47,921,212.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,570,863.81)	(19,394,149.07)
39209	Зам, гүүрийн байгууламж	23,886,000.00	23,886,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(21,286,516.71)	(21,683,616.71)
39211	Тусгай зориулалттай тоног төхөөрөмж	15,872,925.05	15,872,925.05
39214	Бусад үндсэн хөрөнгө	75,880,879.12	75,880,879.12
39215	Хуримтлагдсан элэгдэл	(33,664,828.11)	(41,979,937.39)
393	Биет бус хөрөнгө	43,762,400.00	43,762,400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,162,400.00	44,162,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(400,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,112,447,240.85	1,257,626,142.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	691,277.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	691,277.04
413	Өглөг	-	691,277.04
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	691,277.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,112,447,240.85	1,256,934,865.19
51	Засгийн газрын хувь оролцоо	1,112,447,240.85	1,256,934,865.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		653,858,386.73	653,858,386.73
51101	Өмч: - төрийн	653,858,386.73	653,858,386.73
512	Хуримтлагдсан үр дүн	12,045,950.17	156,533,574.51
51210	Өмнөх үеийн үр дүн	12,045,950.17	12,045,950.06
51220	Тайланг үеийн үр дүн	-	144,487,624.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	446,542,903.95	446,542,903.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,112,447,240.85	1,257,626,142.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	487,000,460.00	724,831,570.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	407,268,000.00	685,326,570.57
120	Нийтлэг татварын бус орлого	12,360,000.00	179,331,770.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,360,000.00	179,331,770.57
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,360,000.00	179,331,770.57
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	394,908,000.00	505,994,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	394,908,000.00	505,994,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,732,460.00	39,505,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,732,460.00	39,505,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	79,732,460.00	39,505,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	478,803,119.74	580,343,946.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	478,803,119.74	580,343,946.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	468,605,403.12	546,562,113.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,071,200.00	394,745,834.62
210101	Үндсэн цалин	244,454,400.00	271,387,132.62
210102	Нэмэгдэл	36,144,100.00	86,214,560.00
210104	Урамшуулал	27,472,700.00	37,144,142.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,508,900.00	50,283,000.00
210201	Тэтгэврийн даатгал	26,186,000.00	31,757,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,080,600.00	3,587,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,464,700.00	2,869,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	616,200.00	4,022,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,161,400.00	8,045,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,800,000.00	30,706,689.00
210301	Гэрэл, цахилгаан	5,921,203.00	4,807,969.00
210302	Түлш, халаалт	36,828,797.00	22,302,720.00
210303	Цэвэр, бохир ус	2,050,000.00	3,596,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,333,490.00	5,664,947.00
210401	Бичиг хэрэг	986,000.00	839,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,900,000.00	1,543,350.00
210403	Шуудан, холбоо, ингернэгийн төлбөр	461,000.00	596,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	999,877.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	986,490.00	1,685,720.00
2105	Нормативт зардал	21,493,980.00	16,180,895.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	66,000.00
210502	Хоол, хүнс	21,393,980.00	16,114,895.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	700,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	700,000.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,597,833.12	46,780,747.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	968,000.00	967,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,832,360.00	1,672,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,797,473.12	44,141,247.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,197,716.62	33,781,833.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,197,716.62	9,413,382.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,952,816.50	7,737,312.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,244,900.12	1,676,070.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	24,368,451.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24,368,451.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,197,340.26	144,487,624.45
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,197,340.26	144,487,624.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	474,640,460.00	545,499,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	394,908,000.00	505,994,800.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	394,908,000.00	505,994,800.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	394,908,000.00	505,994,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	79,732,460.00	39,505,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	79,732,460.00	39,505,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	79,732,460.00	39,505,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	474,640,460.00	545,499,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	474,640,460.00	545,499,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,011,360.00	511,759,279.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,071,200.00	395,389,445.00
210101	Үндсэн цалин	244,454,400.00	272,030,743.00
210102	Нэмэгдэл	36,144,100.00	86,214,560.00
210104	Урамшуулал	27,472,700.00	37,144,142.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,508,900.00	50,283,000.00
210201	Тэтгэврийн даатгал	26,186,000.00	31,757,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,080,600.00	3,587,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,464,700.00	2,869,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	616,200.00	4,022,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,161,400.00	8,045,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,800,000.00	30,706,689.00
210301	Гэрэл, цахилгаан	5,921,203.00	4,807,969.00
210302	Түлш, халаалт	36,828,797.00	22,302,720.00
210303	Цэвэр, бохир ус	2,050,000.00	3,596,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,547,600.00	7,166,647.00
210401	Бичиг хэрэг	956,000.00	877,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,900,000.00	1,543,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	686,600.00	596,500.00
210404	Ном, хэвлэл	105,000.00	400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	-	999,877.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	900,000.00	2,749,420.00
2105	Нормативт зардал	25,883,200.00	19,541,998.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	216,000.00
210502	Хоол, хүнс	24,608,200.00	15,326,998.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,175,000.00	3,999,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	4,400,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,400,460.00	2,771,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	968,000.00	967,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,432,460.00	1,804,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,629,100.00	33,740,521.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,629,100.00	9,372,070.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,729,100.00	7,696,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900,000.00	1,676,070.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	24,368,451.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24,368,451.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	653,858,386.73	446,542,903.95	12,045,950.17	1,112,447,240.85
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	653,858,386.73	446,542,903.95	12,045,950.17	1,112,447,240.85
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	653,858,386.73	446,542,903.95	12,045,950.17	1,112,447,240.85
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	653,858,386.73	446,542,903.95	12,045,950.17	1,112,447,240.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-0.11	-0.11
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	653,858,386.73	446,542,903.95	12,045,950.06	1,112,447,240.74
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	144,487,624.45	144,487,624.45
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	653,858,386.73	446,542,903.95	156,533,574.51	1,256,934,865.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	546,466,600.00	521,131,349.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	546,466,600.00	521,131,349.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	536,103,800.00	511,759,279.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,264,100.00	395,389,445.00
210101	Үндсэн цалин	278,330,500.00	272,030,743.00
210102	Нэмэгдэл	76,629,400.00	86,214,560.00
210104	Урамшуулал	47,304,200.00	37,144,142.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,283,000.00	50,283,000.00
210201	Тэтгэврийн даатгал	34,192,500.00	31,757,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,218,100.00	3,587,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	804,500.00	2,869,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,022,600.00	4,022,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,045,300.00	8,045,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,105,000.00	30,706,689.00
210301	Гэрэл, цахилгаан	5,200,000.00	4,807,969.00
210302	Түлш, халаалт	22,305,000.00	22,302,720.00
210303	Цэвэр, бохир ус	3,600,000.00	3,596,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,310,500.00	7,166,647.00
210401	Бичиг хэрэг	1,510,500.00	877,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,543,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	596,500.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	999,877.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	2,749,420.00
2105	Нормативт зардал	26,041,200.00	19,541,998.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,200,000.00	216,000.00
210502	Хоол, хүнс	20,841,200.00	15,326,998.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	3,999,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,400,000.00	4,400,000.00
210604	Урсгал засвар	8,400,000.00	4,400,000.00
2107	Томилголт, зочны зардал	2,100,000.00	1,500,000.00
210702	Догоод албан томилголт	2,100,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.00	2,771,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.00	967,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,400,000.00	1,804,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,362,800.00	9,372,070.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,362,800.00	9,372,070.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,662,800.00	7,696,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	1,676,070.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч О.Бодьцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Сургуулийн насны хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг олгох, хүүхдэд зөв дадал хүмүүжлийг төлөвшүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, хүмүүнлэг бие даасан иргэн болгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны

жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 563,844.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,276.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 556,613.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 11,132.3 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,038.6 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	250.0	1,584.9	1,334.9
Урьдчилгаа			
Бараа материал	33,555.9	50,121.9	16,566.0
Үндсэн хөрөнгө	1,078,641.3	1,205,919.4	127,278.1
Нийт хөрөнгө	1,112,447.2	1,257,626.2	145,179.0
Өр төлбөр		691.3	691.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,112,447.2	1,256,934.9	144,487.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,112,447.2	1,257,226.2	145,179.0

Авлага дансны үлдэгдэл 1,584.9 мянган төгрөг болж 1334.9 мянган төгрөгөөр өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй 4 ажилтнаас 691.3 мянган төгрөгийн ХХОАТ чөлөөлөлт, захирал С.Оюунчимэгт олгосон цалингийн урьдчилгаа 400.0 мянган төгрөгийг суутгаагүй, 243.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг илүү суутган тооцоноос зэргээс тус тус шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,205,919.4 мянган төгрөг болж 127,278.1 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн хөрөнгө оруулалтаар /2 ариун цэврийн байгууламж, жаргалан кафе, жишиг анги/ 171,419.3 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн, тайлант жилийн элэгдлийн зардал нь 44,141.2 мянган төгрөгийн болсон байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 691.3 мянган төгрөг болж өссөн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс ХХОАТ суутган тооцоноос шалтгаалжээ

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,256,534.9 мянган төгрөг болж 144,087.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 237,831.2 мянган төгрөгөөр буюу 48.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө болон төлбөргүй шилжүүлсэн авсан хөрөнгийн хэмжээ өссөнөөс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 101,940.7 мянган төгрөгөөр буюу 21.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хангамжийн материал, норматив зардал, эд хогшил, бусад урсгал зардал бага хэмжээгээр буурсан ч цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 28.5 хувиар буюу 98,848.7 мянган төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 24,368.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 610,999.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 610,999.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65,499.9 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 545,499.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 545,499.8 мянган төгрөгийг санхүүжилт авсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүжилт 545,499.8 мянган төгрөгийн авснаас урсгал үйл ажиллагаанд 521,131.3 мянган төгрөгийг зарцуулж, 24,368.4 мянган төгрөгийг орон төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 521,131.3 мянган төгрөг байгаа нь зардлыг 24,368.5 мянган төгрөгөөр хэмнэсэн холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 521,131.3 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цалин болон холбогдох зардлыг 14,432.0 мянга, норматив зардал 2,250.6 мянга, томилолтын зардал 600.0 мянган, бусдаар гүйцэтгүүлэх бараа ажил үйлчилгээний зардлыг 4,257.3 мянга, бараа ажил үйлчилгээний бусад зардал 2,828.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар болон бусад төрлийн орлого нэмэлт дансаар орж ирээгүй болно.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 111 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж, 40 мэдээлэл хуулийн хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Итгэл" үзүүлсэн тул зөвлөмж өгөгдөөгүй болно.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,643.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 691.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 485.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 8,379.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 3,087.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 4 ажилтны цалингийн орлогоос нийт 691.3 мянган төгрөгийн татвар суутгаж, авлага, өглөг үүсгээгүй байсан тул санхүүгийн тайланд залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар хүнсний материал нөөцлөх хэмжээнээс хэтрүүлэн нөөцөлсөн 485.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 7,687.7 мянга, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутгасан 691.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага тус тус хүргүүлээ.

1. Тайлант онд 485.5 мянган төгрөгийн хүнсний материал илүү нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэсэн заалтууд, оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд 5.0 сая болон түүнээс дээш төгрөгийн мэдээлбэл зохих 7,687.7 мянган төгрөгийн 1 зардлын гүйлгээг мэдээлээгүй, 157 мэдээллээс 40 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн

заалттай нийцэхгүй, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 4 ажилтны цалингийн орлогоос нийт 691.3 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ...” гэсэн заалтууд, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 3,087.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2018-2019 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 2019 оны эцэст илүү нөөцөлсөн хүнсний материалд тогтоосон 3,087.9 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан анхан шатны баримтыг харилцахын баримтад хавсаргаагүй байна.
- 1.2. Эрсдэл: Хууль мөрдөгдөхгүй байх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг мөрдөн ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/21/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гурванзагал сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд 485.5 мянган төгрөгийн хүнсний материал илүү нөөцөлсөн байна.	485.5	Төлбөрийн акт	Захирлын үүрэг гүйцэтгэгч	О.Бодьцэцэг
2	Тайлант онд 5.0 сая болон түүнээс дээш төгрөгийн мэдээлбэл зохих 7,687.7 мянган төгрөгийн 1 зардлын гүйлгээг мэдээлээгүй, 157 мэдээллээс 40 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож шилэн дансны цахим мэдээллийн санд мэдээлсэн байна.	7,687.7	Албан шаардлага	Захирлын үүрэг гүйцэтгэгч	О.Бодьцэцэг
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 4 ажилтны цалингийн орлогоос нийт 691.3 мянган төгрөгийн татвар суутгасан байна.	691.3	Албан шаардлага	Захирлын үүрэг гүйцэтгэгч	О.Бодьцэцэг
4	хүнсний материалд тогтоосон 3,087.9 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан анхан шатны баримтыг харилцахын баримтад хавсаргаагүй байна.	3,087.9	Зөвлөмж	Захирлын үүрэг гүйцэтгэгч	О.Бодьцэцэг
ДҮН		11,952.4			

